
*ҮАГазраас 2016 онд нийлүүлэх аудитын болон үйл ажиллгааны төлөвлөгөөний дагуу
хийсэн нийцлийн аудитын тайлан*



ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2016 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Асуудал 1
Аудитын менежер О.Амаржаргал	Орон нутгийн хурлын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан байна. 5-8
Ахлах аудитор Ц.Базарсад Ц.Саранчимэг	Асуудал 2
Шинжээч Ц.Хишигжаргал А.Батлхагва	Сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг батлагдсан төсвийн дагуу хянаж хүлээн авсан байна..... 9-10
2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр	Дүгнэлт 11
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Зөвлөмж 12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70273204 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	Холбогдох байгууллагын санал:
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал 13
	Саналд өгсөн тайлбар13

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
СТХ	Сонгуулийн тухай хууль
СТБ	Сонгуулийн төв байгууллага
САСТХ	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
ТАХ	Төрийн аудитын тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НББ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх
- Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх

Аудитад аймгийн болон сумдын сонгуулийн хороодын санхүүгийн баримт материал, батлагдсан төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл, цагийн бүртгэл, урамшуулал, хоол унааны мөнгө олголт, бараа материалын тайлангууд, сонгуулийн хороо болон хэсгийн хороодын даргын захирамжууд зэрэг материалууд хамрагдсан болно.

Сумдын Сонгуулийн хороод санхүүгийн баримт болон зарцуулалтын тайлангуудыг 2016 оны 10 сарын 28-нд, аймгийн Сонгуулийн хороо сонгуулийн зардалын зарцуулалтын тайлан болон санхүүгийн баримтуудыг 2016 оны 11 сарын 08-нд Аудитын байгууллагад ирүүлсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитыг АДБОУС-4000, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

Төрийн аудитын тухай хууль

Төсвийн тухай хууль

Сонгуулийн тухай хууль

Сонгуулийн төв байгууллагын тухай

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль

СЕХ-ны 2016 оны 4-р тогтоол

Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль, тогтоомжууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, Ахлах аудитор Ц.Базарсад, Ц.Саранчимэг, шинжээч Ц.Хишигжаргал, А.Батлхагва нар 2016 оны 11-р сарын 08-ноос 11-р сарын 28-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Асуудал 1

Орон нутгийн хурлын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан байна.

1.1 Төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон эсэх

Орон нутгийн хурлын сонгуулийн төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлаагүйгээс зарим зардлыг бодит байдлаас илүү тооцсон байна.

Төв аймгийн сонгуулийн хороонд Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу 421624.6 мянган төгрөг хувиарлагдсан байна. Үүнийг дараах байдлаар баталж ирүүлсэн байна. Үүнд:

- СЕХ-ны 2016 оны 9 сарын 15-ны өдрийн 257 тоот албан бичгийн 2-р хавсралтаар 139874.0 мянган төгрөг,
- 2016 оны 10 сарын 10-ны өдрийн 621 тоот албан бичгийн 2-р хавсралтаар 281750.6 мянган төгрөг,

СЕХ-оос төсөв хуваарилсан тухай бүрд зардал тус бүрийг тооцоолсон аргачлал, зөвлөмжийг ирүүлсэн.

СЕХ-оос төсвийн санхүүжилтийг тухайн аймгийн газар нутгийн хэмжээ, сонгогчийн болон сум, хэсгийн тоо, тэдгээрт ажиллагсадын тоо зэргийг харгалзан тооцож олгосон ба зарим нэг зардлыг тооцохдоо бусад аймагтай адил жишгээр тооцсон нь дараах зардлууд илүү төсөвлөхөд нөлөөлсөн байна. Жишээ нь: сумаас аймгийн төв орох унааны зардлууд, аймгийн төвд хийх сургалтын автомашины /шатахуун/ зардлууд бодит байдлаас илүү тооцогдсон байна.

Төв аймгийн сонгуулийн хороо нь 27 сумдын хэсгийн хороодод 323839.2 мянган төгрөгийг, аймгийн сонгуулийн хороонд 97785.4 мянган төгрөгийг зарцуулахаар хуваарилсан байна. Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодын зардлыг хуваарилахдаа сумдын хүн амын тоонд үндэслэн тогтоосон хэсгийн хорооны тоо, ажиллагсадын тоонд болон СЕХ-ноос ирүүлсэн аргачлал зөвлөмжийн дагуу тооцогджээ.

Харин унааны зардал болон автомашины зардлуудыг бодит байдалд тулгуурлалгүй, СЕХ-ны жишгээр тооцож хуваарилсан нь бодит хэрэгцээ шаардлагаас илүү тооцогдсон байна.

1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн үйл ажиллагааны зардлаас 49898.4 мянган төгрөг буцаан төвлөрүүлж арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

Төв аймгийн Сонгуулийн хороо нь СЕХорооноос хувиарлагдсан 421624.6 мянган төгрөгийг хоёр удаагийн санхүүжилтээр авсан байна. Төв аймгийн сонгуулийн хорооны төрийн сан дахь 140022001 тоот дансаар 2016 оны 9 сарын 16-аас 2016 оны 11 сарын 02-ны хооронд 371726.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 49898.4 мянган төгрөгийг СЕХороонд буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Архуст сум 484.0 мянган төгрөг,
- Баян сум 260.4 мянган төгрөг,
- Баян-өнжүүл сум 1452.0 мянган төгрөг,
- Баянхангай сум 260.4 мянган төгрөг,
- Өндөрширээт сум 2136.8 мянган төгрөг,
- аймгийн Сонгуулийн хороо 45304.8 мянган төгрөг.

Бусад сумд батлагдсан төсвийн хэмжээнд тулгаж зарцуулсан байна.

СЕХ-ноос ирүүлсэн төсвийг өгөгдсөн зөвлөмжийн дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэхийг шалгахад зохих хэмнэлтүүд гарсан нь аймаг, сумдын сонгуулийн хороодоос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлангаар харагдаж байна. Төв аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд аудит хийхэд дараах хэмнэлтүүд гарсан байна. Зардалын хэмнэлт болон хэмнэлт гарах шалтгаан нь:

- Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардлаас 377.2 мянган төгрөгийг хэмнэсэн.
- Сургалтын зардлаас 5997.6 мянган төгрөг гэрчилгээжүүлэх сургалт хийгээгүйгээс хэмнэгдсэн.
- Унааны зардлаас 3927.9 мянган төгрөгийг орон нутгийн маршрутын дагуу тооцсоноос хэмнэгдсэн.
- Хууль тогтоомж сурталчилах зардлаас 2850.0 мянган төгрөгийг техник тоног төхөөрөмжийн давуу талуудыг ашигласанаар хэмнэгдсэн.
- Томилолтын зардлаас 1847.4 мянган төгрөгийг сонгуулийн хорооны гишүүдийн сургалтыг 1 хоног хийсэнээс хэмнэгдсэн.
- Саналын хуудас авах зардлаас 1593.0 мянган төгрөг хэмнэгдсэн нь аймгийн Сонгуулийн хороо саналын хуудас татах, тараах ажлыг бусад ажилтай хамтатган хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.
- Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардлаас 3152.0 мянган төгрөг хэмнэсэн нь 2016 оны 6 дугаар сард болсон УИХ, аймгийн ИТХ-ын сонгуулиар дээрх хөрөнгө бэлтгэгдсэнтэй холбоотой.
- Болзошгүй зардлаас 3000.0 мянган төгрөгийг гэнэтийн зүйл гараагүйгээс хэмнэгдсэн.
- Сурталчилгааны материал хүргэх зардлаас 1350.0 мянган төгрөгийг хэмнэсэн.
- ИРС машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардлаас 12728.5 мянган төгрөг хэмнэгдсэн нь тус машиныг саналын хуудасны хамт сумын сонгуулийн хороонд хүлээлгэж өгсөн учир сумын сонгуулийн хорооны гишүүд аймагт ирж хүлээн авах зардал хэмнэгдсэн, мөн сумын сонгуулийн хороонд унааны зардлыг хуваарилахдаа сонгуулийн дүн болон ИРС машиныг аймагт буцаан авч ирэх унааны зардал тухайн хуваарилсан дүнд багтаасан зэрэг арга хэмжээ авсантай холбоотой байна.

- Сонгуулийн урамшуулал хоолны зардлаас 11922.8 мянган төгрөг хэмнэгдсэн нь санал авах байранд ажиллах төрийн албан хаагчид, зохион байгуулагчид нилээд олон сумдад батлагдсан тоондоо хүрч ажиллаагүйтэй холбоотой байна.

Сонгуулийн зардалын гүйцэтгэлд аудит хийхэд сонгууль зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай уртасгагч, бичгийн тавиур, тооны машин, галын хор, флаш диск, тугны суурь, хяналтын камер гэх мэт дахин ашиглах боломжтой эд зүйлсийг холбогдох зардалаас гарган худалдан авчээ. Сонгуулийн үйл ажиллагааны дууссаны дараа дээрх эд зүйлсийг сумдын ЗДТГазарт шилжүүлэн өгч данс бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Нийт 26 сумын 93 санал авах байранд нийт 8350.0 мянган төгрөгийн бараа материал авсаныг сумдын ЗДТГазрын данс бүртгэлд тусгуулахаар албан шаардлага бичигдлээ. /Хавсралт № 1/

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ны зөвлөмж, батлагдсан төсөв, төсвийн зардалын зүйлийн дагуу зардал гаргасан боловч сургалтын зардлаас 789.0 мянган төгрөгийн 1 ширхэг ус буцалгагч, 1412.2 мянган төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж худалдаж авсан байна.

Төв аймгийн Сонгуулийн хороо нь сонгуулийн үйл ажиллагааны зардлаас 49898.4 мянган төгрөгийг СЕХ-с өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн аривлан хэмнэлттэй зарцуулсан байна.

Эдгээрийг эс тооцвол аймгийн сонгуулийн хороо нь “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайланг гаргах тухай журам”-ын дагуу батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна. Сумдын сонгуулийн хороодын харилцах болон материалын тайлангууд, аймгийн сонгуулийн хорооны харилцах дансны баримтуудыг холбогдох журмын дагуу, анхан шатны баримтуудад тавигдах шаардлагын дагуу бүрдүүлэн, хавсаргаж эмх цэгцтэйгээр үдсэн байна.

Асуудал 2

Сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг батлагдсан төсвийн дагуу хянаж хүлээн авсан байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг батлагдсан зардлын дагуу бүрэн тайлагнагдсан байна.

2.1 Төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэх

СЕХ нь Аймгийн Сонгуулийн хорооны төсвийг тооцож, санхүүжилт хийх тухай бүрд нь зардлуудыг тооцох аргачилал зөвлөмжийг ирүүлж байжээ.

СЕХ-2016 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 3-р хавсралтын дагуу сумдын сонгуулийн хороод нь төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, хянуулан аймгийн сонгуулийн хороонд нэгтгүүлсэн байна.

Аймаг, сумдын Сонгуулийн хорооны зардлын нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсөв 421624.6 мянган төгрөг, гүйцэтгэлээр 371726.2 мянган төгрөгийг зарцуулж, 49898.4 мянган төгрөг хэмнэгдсэнийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна. Хэмнэгдсэн нийт төсвийн 45304.7 мянган төгрөг нь аймгийн сонгуулийн хорооноос, сумдын сонгуулийн хорооноос 4593.6 мянган төгрөг тус тус хэмнэгдсэн байна.

Төв аймгийн Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан /мянган төгрөг/				
№	Зардлын нэр	НИЙТ ДҮН		
		төсөв	гүйцэтгэл	хэтрэлт хэмнэлт
1	Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх	2700.0	2322.8	-377.2
2	Тогтоол проткол бусад маягт хэвлүүлэх зардал	350.0	350.0	
3	Сургалтын зардал	22636.0	16638.4	-5997.6
4	Бичиг хэргийн зардал	14420.0	13891.5	-528.5
5	Шуудан холбооны зардал	14360.0	14205.0	-155.0
6	Унааны зардал	52250.0	48322.1	-3927.9
7	Хууль тогтоомж суртчилах зардал	8000.0	5150.0	-2850.0
8	Санал авах байр бэлтгэх зардал	19900.0	19861.5	-38.5
9	Саналын хуудас хүргэх	8521.0	6928.0	-1593.0
10	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	13966.0	1237.5	-12728.5
11	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	600.0	170.0	-430.0
12	Томилолтын зардал	6258.0	4410.6	-1847.4
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	4802.0	1650.0	-3152.0
14	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	212533.6	201131.6	-11402.0
15	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	34478.0	33957.2	-520.8

16	Болзошгүй зардал	3000.0		-3000.0
17	Сурталчилгааны материал хүргэх зардал	2850.0	1500.0	-1350.0
<i>Нийт дүн</i>		421624.6	371726.2	-49898.4

Аймаг, сумдын Сонгуулийн хороод Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 09 дүгээр сарын 15-ны 257 тоот, 2016 оны 10 дугаар сарын 10-ны 621 тоот 2016 оны 10 дугаар сарын 28-ны 287 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу хуваарилагдсан төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг шалгахад:

- Төв аймгийн сонгуулийн санал хураалтын дүн гарахад Баяндэлгэр, Баянхангай, Бүрэн, Заамар, Угтаалцайдам сумдын тус бүр 1 тойрогт 1 мандатад тэнцүү тооны санал авсан 12 нэр дэвшигч гарсан тул 2016 оны 10 дугаар сарын 29-ний өдөр дахин санал хураалтыг зохион байгуулах болсон. Иймд аймгийн сонгуулийн хорооноос 2016 оны 10 сарын 26-ны 48 тоот албан бичгээр Сонгуулийн хорооны төсөвт өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргасаны дагуу дахин сонгуулийн зардалд үлдэгдэл төсвөөс 6 сумын зардалд 2950.0 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооноос зөвшөөрөлийн дагуу зарцуулсан байна.
- Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 10 дугаар сарын 04-ны 618 тоотоор ирүүлсэн Авилгатай тэмцэх газрын 01/6654 тоот зөвлөмжийн дагуу аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг батлагдсан зардлын дагуу Шилэн дасанд бүрэн байршуулсан байна.

2.2 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх

Сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг батлагдсан төсвийн дагуу хянаж хүлээн авсан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4-д “Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажилласан тухай ажлын тайланг ирүүлсэн.

Сумдын Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийн тайланг хэсгийн хороо тус бүрээр гаргуулж, мөнгөн хөрөнгийн болон, материалын тайланд холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэн, үдэж цэгцлэн аймгийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлаагүйгээс зарим зардлыг бодит байдлаас зөрүүтэй тооцсон байна.
2. Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг батлагдсан зардлын зүйлээр үнэн зөв тайлагнагдсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн:

ҮАГазраар уламжлан Сонгуулийн ерөнхий хороонд зөвлөх нь

1. Сонгуулийн ерөнхий хороо нь төсвийн зардлын зүйлийг хувиарлахдаа орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлан зардлыг бодитой үндэслэлтэй төлөвлөхөд анхаарч ажиллах

Ахлах аудитор

Ц.Базарсад

Ц.Саранчимэг

Шинжээч

Ц.Хишигжаргал

А.Батлхагва

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал


**ТӨВ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**
41100 Зуунмод, Төв аймаг
Утас: Факс:
2016.11.29 № 50
танай _____ -ны № _____ -т
АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн Аудитын газраас ирүүлсэн орон нутгийн сонгуулийн зардлын нийцлийн аудитаар өгөгдсөн дүгнэлт зөвлөмжийг аймгийн Сонгуулийн хороо хүлээн зөвшөөрч байна.

ДАРГА  М.ОТГОНБАТ

My doc: -/2016 on/ A5 toot

